



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Цант Орхон ААТҮГ-ын 2021 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/08-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040

Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036

Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор:
Гэрээгээр гүйцэтгэсэн Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн
Захирал Ш.Ичинхорлоо
Утас77280808 Цахим хаяг:nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Төлбөрийн акт	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УИХ	Улсын их хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.15 № СЭА-2022/08-НА-СТА-ОНА

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

018020388

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө	306,521,126.40	457,922,479.11
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	199,227,381.89	313,569,977.21
1.1.2	Дансны авлага	54,532,759.17	89,207,565.17
1.1.6	Бараа материал	52,760,985.34	55,144,936.73
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	306,521,126.40	457,922,479.11
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	23,860,122,774.97	23,475,237,682.52
1.2.1	Үндсэн хөрөнгө	23,860,122,774.97	23,475,237,682.52
1.2.2	Биет бус хөрөнгө	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	23,860,122,774.97	23,475,237,682.52
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	24,166,643,901.37	23,933,160,161.63
2.1	Нийт өр төлбөр	1,668,626.23	5,147,403.04
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	1,668,626.23	5,147,403.04
2.1.1.3	Татварын өр	1,668,626.23	5,147,403.04
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,668,626.23	5,147,403.04
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,917,096,129.00	1,917,096,129.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,765,404,928.04	22,765,404,928.04
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(517,525,781.90)	(754,488,298.45)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(288,688,045.16)	(240,998,266.55)
2.3.9	Өмнөх үеийн ашиг	(228,837,736.74)	(513,490,031.90)
2.3.11	Эздийн өмчийн дүн	24,164,975,275.14	23,928,012,758.59
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	24,166,643,901.37	23,933,160,161.63

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	816,785,626.24	904,184,669.38
2	Борлуулалтын өртөг	994,124,604.42	1,106,284,181.24
3	Нийт ашиг (алдагдал)	(177,338,978.18)	(202,099,511.86)
4	Түрээсийн орлого	4,703,636.32	4,862,727.25
5	Хүүний орлого	2,028,508.87	0.00
8	Бусад орлого	2,311,632.00	3,249,692.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	28,714,477.60	26,859,266.75
12	Бусад зардал	68,646,043.32	3,723,188.18
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	(16,428,719.73)
17	Бусад ашиг (алдагдал)	(23,032,323.25)	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(288,688,045.16)	(240,998,266.55)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(288,688,045.16)	(240,998,266.55)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(288,688,045.16)	(240,998,266.55)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,917,096,129.00	22,765,404,928.04	(228,837,736.74)	24,453,663,320.30
Залруулсан үлдэгдэл	1,917,096,129.00	22,765,404,928.04	(228,837,736.74)	24,453,663,320.30
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(288,688,045.16)	(288,688,045.16)
2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,917,096,129.00	22,765,404,928.04	(517,525,781.90)	24,164,975,275.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			4,035,750.00	4,035,750.00
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(240,998,266.55)	(240,998,266.55)
2021оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,917,096,129.00	22,765,404,928.04	(754,488,298.45)	23,928,012,758.59

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020оны 12-р сарын 31	2020оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	888,484,106.01	943,408,911.12
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	888,484,106.01	943,408,911.12
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	878,686,226.01	929,473,714.40
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,123,248.00	6,138,204.00
	Бусад мөнгөн орлого	6,674,632.00	7,796,992.72
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	820,913,729.31	798,935,015.80
	Ажиллагчдад төлсөн	314,375,526.59	341,715,936.63
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	74,217,870.43	90,674,943.96
	Бараа материал худалдан авахад төлсөн	175,321,329.00	141,963,030.00
	Ашиглалтын зардалд төлсөн	59,641,568.31	65,405,694.45
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	53,035,450.00	60,225,720.00
	Татварын байгууллагад төлсөн	126,114,267.98	89,171,505.76
	Даатгалын төлбөрт төлсөн	2,229,210.00	2,037,675.00
	Бусад мөнгөн зарлага	15,978,507.00	7,740,510.00
	Хүлээн авсан хүүний орлого	2,028,508.87	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	45,161,181.82	26,661,300.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	45,161,181.82	26,661,300.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(43,132,672.95)	(26,661,300.00)
	Мөнгөн зарлагын дүн (-)	(6,115,930.00)	(3,470,000.00)

5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	18,321,773.75	114,342,595.32
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	180,905,608.14	199,227,381.89
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	199,227,381.89	313,569,977.21

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
	Орлогын нийт дүн	826,575,642.0	912,297,089.35	85,721,447.35	110.4
	Цэвэр борлуулалт	816,575,646.0	904,184,669.38	87,609,023.38	110.7
1.1	Цэвэр усны борлуулалт	8,000,00.0	19,360,134.49	11,360,134.49	244.1
1.2	Бохир усны борлуулалт	711,547,500.0	757,325,870.89	47,778,370.89	106.4
1.3	Халуун усны үйлчилгээний орлого	26,588,250.0	38,514,213.61	11,925,963.61	144.9
1.5	Зочид буудал, кофены үйлчилгээний орлого	70,439,892.0	88,984,450.39	18,544,558.39	126.3
1.6	Бусад үйл ажиллагааны орлого	10,000,000.0	8,112,419.97	(1,887,580.03)	81.1
	Нийт зардлын дүн	1,153,068,232.0	1,153,295,356.0	15,240.40	104.6
1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,153,068,232.0	1,153,295,356.0	16,781.7	105.7
2	Ерөнхий ба удирдлагын зардал	-	-	-	-
3	Борлуулалтын зардал	(326,492,590.0)	(240,998,266.7)	(85,494,323.3)	73.8
4	Цэвэр ашиг алдагдал				
5	Хөрөнгө оруулалт, их засвар				
24	Ашиг, алдагдал	(326,492,590.0)	(240,998,266.7)	(85,494,323.3)	73.8

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Цант орхон” ААТҮГ нь эрхэм зорилгоо “Мандал сумын үйлдвэрийн болон ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэршүүлж, гэр хорооллын айл өрхүүдийг ундны цэвэр усаар ханган нийлүүлж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж, байгаль орчинд ээлтэй жишиг байгууллага болох гэж тодорхойлжээ.

“Цант Орхон” ААТҮГ-ын дүрэмд нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийг цэвэр усаар хангах.
- Аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйл ажиллагаа явуулах.
- Зочид буудал, үсчин гоо сайхан, дулаан гражаар үйлчилж гадаад дотоод худалдаа эрхлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн статустай бүртгэгдэж, 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Цант Орхон ” ААТҮГ нь аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Цант Орхон” ХХК нэртэйгээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Цант Орхон” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-д “ Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, 19 дүгээр зүйл “Аймаг, нийслэлийн Хурлын бүрэн эрх”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх “**Аймаг, нийслэлийн Хурал нь харьяалах нутаг дэвсгэртээ энэ хуулийн 18 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 тоот тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор “Айл өрхийн болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх,
- Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 242 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах түр журам”, “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны төлбөр тооцоог зохицуулах түр журам” гэх мэт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Цант Орхон” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233,483.7 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	199,227.4	313,570.0	114,342.6
Авлага	54,532.8	89,207.6	34,674.8
Бараа материал	52,760.9	55,144.9	2,384.0
Үндсэн хөрөнгө	23,860,122.8	23,475,237.7	(684,885.1)
Нийт хөрөнгө	24,166,643.9	23,933,160.2	(233,483.7)
Богино хугацаат өр төлбөр	1,668.6	5,147.4	(3,478.8)
Эздийн өмчийн дүн	24,164,975.3	23,928,012.8	(236,962.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	24,166,643.9	23,933,160.2	(233,483.7)

Байгууллагын касс 5,017.3 мянган төгрөг, банкин дахь харилцах дансанд 308,552.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнаж, өмнөх оноос мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 114,342.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд касс болон харилцахаар 1,348,538.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,234,196.0 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 34,674.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төрөөс хариуцах дулаан, цэвэр, бохир усны төлбөрийн 40,250.0 мянган төгрөг, Мандал сумын ЗДТГ-аас тус газрын буудлын барилгыг тусгаарлах байр болгосонтой холбоотойгоор төлөх ковидын байрны төлбөрийн 46,755.0 мянган төгрөгийн авлага

үүссэнээс шалтгаалсан байна. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 84,607.0 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 4,600.0 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,144.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,384.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 208,444.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 206,060.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 20,498,914.2 мянган төгрөг болж 54,173.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр 10,410.9 мянган төгрөгийн 4 төрлийн дулаан, ус хангамжийн насос, 6,818.1 мянган төгрөгийн сэлбэг худалдан авч тээврийн хэрэгслийг капиталжуулсан болон 1,453.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,690.9 мянган төгрөгийн компьютер хэрэгсэл худалдан авч, аймгийн ИТХТ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор 74,547.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталснаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 5,147.4 мянган төгрөг нь өмнөх оны НӨАТ-ын дутуу төлөлтийг тайлант онд шалгаж, өглөг үүсгүүлэн бүртгүүлсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 23,928,012.8 мянган төгрөг болж, 236,962.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Цант Орхон” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тус үйлдвэрийн газрын / ААТҮГ болоогүй ХХК байсан үед / Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 08-ны 05/21 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 826,575.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,153,068.2 мянган төгрөгөөр, алдагдлыг 326,492.5 мянган төгрөг байхаар тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 912,297.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,153,295.3 мянган төгрөгийн зардал гарган, 240,998.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт алдагдал 240,998.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 85,494.3 мянган төгрөг буюу 10.7 хувиар буурсан нь тайлант хугацаанд зөөврийн усан хангамжаар Мандал сумын 650 айл өрхийг цэвэр усаар хангахаас гадна улсын төсвөөр бохир усны шугам хоолой, өргөх станцыг барьж, бохирын нэгдсэн шугам хоолойд хэрэглэгчдийг холбон үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,153,295,3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 4.6 хувиар хэтэрсэн нь зарим зардал төлөвлөсөн хэмжээнээс илүү зарцуулагдсантай холбоотой байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Цант Орхон” ААТҮГ-ын / цаашид “Цант Орхон” ААТҮГ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Ц.Энхтуяа гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, 2 дахь шатны хяналтыг Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар хэрэгжүүлсэн.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд үйлдвэрийн газрын өөрийн дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Цант Орхон” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,153,295.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,532.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 8,073.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, -6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Цант Орхон” ААТҮГ нь тайлант онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 142 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д *“Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар*

хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасныг зөрчин нийтийн ахуйн үйлчилгээний салбарын 90 жилийн ойд 913.0 мянган төгрөгийг, шинэ жилийн арга хэмжээнд 1,042.0 мянган төгрөгийг зэрэг нийт 1,955.0 мянган төгрөгийг шагнал, урамшуулалд зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,612.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 4,848.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	3,612.6	2	3,612.6	-	-	100.0
Зөвлөмж	4	4,848.8	3	4,848.8	1	-	75.0
Нийт дүн	6	8,461.4	5	8,461.4	1		83.3

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал үгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 101,637.9 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 101,248.9 мянган төгрөгийн 3 алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, 389.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Залруулагдаагүй 389.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 11,532.9 мянган төгрөгийн түвшнээс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 101,248.9 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа.

- Орлогын дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгө акталсны гарз 16,428.7 мянган төгрөгийг тооцож, бүртгэж, тайлагнаагүй,
- Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 16,428.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,
- Ашиглалтын болон цалин хөлсний зардлын 68,391.5 мянган төгрөгийн зардлыг ерөнхий ба удирдлагын зардалд хуваарилалгүй шууд ББӨ-т оруулан тооцож, тайлагнасан.

8.2 Төлбөрийн акт

1. Тайлант онд байгууллагын эд хөрөнгийг түрээслүүлсний 1,945.1 мянган төгрөгийн 20 хувь болох 389.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2014 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн өмч, эд хөрөнгийг түрээслүүлэх журмын 2.14 дэх “Түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 20 хувийг орон нутгийн төсвийн орлогын дансанд байршуулна” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	“Цант Орхон” ААТҮГ	СЭА-2022/08/НА-СТА-ОНА	Орлогын дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгө акталсны гарз 16,428.7 мянган төгрөгийг тооцон бүртгэж тайлагнаагүй.	Аудитын явцад залруулсан	1	16,428.7	1	16,428.7							
2	“Цант Орхон” ААТҮГ	СЭА-2022/08/НА-СТА-ОНА	Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 16,428.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,	Аудитын явцад залруулсан	1	16,428.7	1	16,428.7							
3	“Цант Орхон” ААТҮГ	СЭА-2022/08/НА-СТА-ОНА	Байгууллагын ашиглалтын болон цалин хөлсний зардлын 68,391.5 мянган төгрөгийн зардлыг ерөнхий ба удирдлагын зардалд хуваарилалгүй шууд ББӨ-т оруулан тооцсон,	Аудитын явцад залруулсан	1	68,391.5	1	68,391.5							
4	“Цант Орхон” ААТҮГ	СЭА-2022/08/НА-СТА-ОНА	Түрээсийн орлогын 20 хувийг төсөвт төвлөрүүлээгүй	Төлбөрийн акт	1	389.0			1	389.0					
ДҮН					4	101,637.9	3	101,248.9	1	389.0					
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															
1	“Цант Орхон” ААТҮГ	СЭА-2022/08/НА-СТА-ОНӨ	Шилэн дансны цахим системд мэдээллээ хугацаанд нь байршуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, 7 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн	1	-					1				

4	“Цант Орхон” ААТҮГ	СЭА-2022/08/НА-СТА-ОНА	Нийтийн ахуйн үйлчилгээний 90 жилийн ой болон шинэ жилийн арга хэмжээнд 1,955.0 мянган төгрөгийг шагнал, урамшуулалд зарцуулсан	Төлбөрийн акт	1	1,955.0			1	1,955.0	1					
	ДҮН				2	1,955.0			1	1,955.0	1					
	НИЙТ ДҮН				6	103,592.9	3	101,248.9	2	2,344.0	1					